“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХЭ-ИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 09 сарын 21 Улаанбаатар хот

“Бодь Даатгал” ХК-ийн ХЭ-ийн ээлжит хурал 2026 оны 09-р сарын 21-ний өдрийн 11:09 цагаас “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн www.agm.mn веб сууртай цахим хаягаар дамжуулан цахим хэлбэрээр болж, Хурлын дарга Гүйцэтгэх захирал А.Энхжаргал, удирдлагын багаас М.Мөнхбаатар, Ж.Наранцэцэг, ТУЗ-ийн дарга Б.Билэгт, ТУЗ-н гишүүн Ш.Бэжид, Тооллогын комиссын дарга Х.Сарангоо болон тооллогын комиссын бүрэлдэхүүн, Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ :

1. Компанийн 2026 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах,
2. Брэнд бүүк танилцуулах;
3. Компанийн оноосон нэрийг өөрчлөхийг хэлэлцэж, батлах;
4. Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбоотойгоор шинэчилсэн дүрмийн төслийг хэлэлцэж, батлах;

Ө.Батчимэг: Сайн байцгаана уу, Хувьцаа эзэмшигчдээ. ХЭЭБус хурал эхлэхэд бэлэн боллоо. 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр. Даваа гариг. 11 цаг 09 минут. Бодь Даатгал хувьцаат компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо.

Б.Билэгт: Сайн байцгаана уу? Эрхэм хувьцаа эзэмшигчидээ, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хурлыг Гүйцэтгэх захирал А.Энхжаргал удирдан явуулхаар томилогдсон болно.

Х.Сарангоо: Бодь даатгал ХК-н хувцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын тогтоол, 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр, Дугаар№ 1, Улаанбаатар хот,

Компаний тухай хуулийн 67, 69.1, 69.2, Бодь даатгал ХК-ийн дүрмийн 7.4, Бодь даатгал компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн Тогтоох нь:

1. Бодь даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 180,078,247 ширхэг энгийн хувьцаа эзэмшигч буюу 20 хувьцаа эзэмшигч оролцож нийт саналын эрх бүхий 231,931,348 ширхэг хувьцаа нь 77.64 хувь болж хуралд оролцогчид болон хурлын дарга мэдээлэлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2, Компанийн дүрмийн 7.4, нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 77.64 хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга Х.Сарангоо, гишүүн Ж.Наранцэцэг, О.Энхжин.

А.Энхжаргал: Та бүхэнд энэ өдрийн хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

НЭГ. Компанийн 2026 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, ХОЁР.брэнд бүүк танилцуулах, ГУРАВ. компанийн оноосон нэрийг

өөрчлөхийг хэлэлцэж, батлах, ДӨРӨВ. Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбоотойгоор шинэчилсэн дүрмийн төслийг хэлэлцэж, батлах зэрэг болно.

Эдгээр асуудлыг хурлын дарга миний бие танилцуулна. Түүний дараа хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт явагдана. Саналын хуудас бөглөх зааврыг тооллогын комисс танилцуулна. Хуралд ХЭ болон ХЭ-ийг төлөөлүүлэн цахимаар оролцож байгаа хурлаас гарсан шийдвэрийн дагуу саналаар оролцох, саналын хуудсыг хүлээн авах ажиллагаа явагдана. Хуралд ХЭ болон ХЭ-г төлөөлөн цахимаар оролцсон хүмүүсээс Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн саналын дүнг тооллогын комиссын тогтоол болгон гаргана. Тооллогын комиссийн тогтоолыг үндэслэн хурлаас гарах тогтоолыг боловсруулж танилцуулна. Хурлаас гарах шийдвэр тогтоолыг хурлын даргын зүгээс танилцуулна.

Та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудлын дарааллын дагуу компанийн эхний хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллааны тайланг танилцуулъя.

А.Энхжаргал: Бид энэ жил зах зээлд цахим орчин дижитал шилжилт хөгжиж буйтай холбоотой бид үйл ажиллагаандаа тодорхой цахимжуулалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнтэй холбоотой бид Богд банкны аппликейшн дээр өөрсдийн үйл ажиллагааг нэвтрүүлж даатгалын мини апп-ийг суулгах ажиллагаа хийгдсэн. Мөн value app буюу санхүүгийн нэгтгэлтэй хамтран ажиллах ажиллагаагаа улам өргөжүүлж өөрсдийн mini app-аа 3 сард байршуулж энэ ажлыг хийж гүйцэтгэсэн. Цахим борлуулалт тодорхой хэмжээнд өсөлт гарсан тоон үзүүлэлтүүдийг гаргасан. Мөн дараагийн ажил болох даатгалын баталгааг цахимаар авдаг болсон. Даатгалын зах зээлд 2023 оноос холбогдох хуулинд өөрчлөлт орсноор баталгаа гаргах процессыг даатгалын компаниуд эрчимтэй хийж гүйцэтгэсэн. Бид ч мөн энэхүү ажлыг 2025 оноос хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор энэ жил тухайн ажлыг цахимжуулах ингэснээр хүн хүчний зардал, цаг хугацааны хувьд түргэн шуурхай байдлаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх ажлуудыг гүйцэтгэсэн. Тухайн үйлчилгээг цахимаар автоматаар хүлээж авдаг болсноор бидний гар ажиллагаа багасах, үйлчилгээ хурдан шуурхай болох, харилцагчийн болон борлуулалтын тоо хэмжээ өсч бодитоор үйл ажиллагаанд дэмжлэг болсон гэж харагдаж байна. Эдгээр үйл ажиллагаатай зэрэгцүүлээд харилцагчаа дараах үйл ажиллагааг үнэ цэнтэй болгосон. Даатгалын үйлчилгээ илүү хүртээмжтэй зах зээлийн тэлэлтээ тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа. Хурдан шуурхай даатгалын үйлчилгээг авах нөхцөл бүрэн бүрдсэн. Банк санхүүгийн үйлчилгээтэй уялдсан шинэ борлуулалтын сувгийг нээсэн.

Зах зээлд бүтээгдэхүүн болон шинэ боломжийг эрэлхийлж ажлласан. Эхний хагас жилд болсон хэд хэдэн томоохон үзэсгэлэн үйл ажиллагаанд тасралтгүй тогтмол оролцсон. Үүнээс дурьдвал “Цэнгэлдэх авто экспо”-д тээврийн хэрэгсэл мөн цахилгаан тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал гэсэн бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. Бид өнгөрсөн жилд цахилгаан тээврийн хэрэгсэлд зориулсан ногоон даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлэд нэвтрүүлээд холбогдох банкуудтай хамтын ажиллагааг хэрэгжүүлж байгаа ба энэ жил мөн энэхүү бүтээгдэхүүн дээр идэвхижүүлэлт хийх зорилгоор нийтийн экспод тасралтгүй оролцож ажиллаа. Мөн Улаанбаатар травел экспо 2026 ул хөдлөх хөрөнгийн салбарын арга хэмжээнд хамтран оролцсон. Ремакс байгууллагатай хамтарч оролцсон. Ул хөдлөхийн зах зээлд ремакс нь хамгийн том тоглогч гэдгийг бүгд мэднэ. Энэхүү арга хэмжээнд 3500- 4000 оролцогч оролцсон. Үүнээс багагүй хамтын ажиллагааг бий болгосон.

Бүтээгдэхүүний шинэчлэлтэй холбоотой хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг шинэчилж санхүүгийн зохицуулах хороонд холбогдох бүртгэлийг хийлгэн энэ жилийн борлуулалт дээр оролцсон. Энэхүү бүтээгдэхүүний даатгалын үнэлгээг 20 сая төгрөг байсныг 100 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн. Хураамжийн хэмжээг 250,000 төгрөг болгон шинэчилсэн. Энэхүү шинэчлэлтэй холбоотой борлуулалтыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн гэж тоон үзүүлэлтээр харагдаж байна. Энэ жилийн төлөвлөгөөнд орон нутгийн салбараас харьцангуй өмнөх жилүүдтэй харьцуулахад осолтгой төлөвлөгөөний гүйцэтгэл ойдор 90-с 100% тай тогтмол явж байна. Бүтээгдэхүүний борлуултын хувь хэмжээнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна гэж үзэж байна.

Засаглал ба хүний нөөц, олон улсын харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр бид багагүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Бид эхний хагас жилийн байдлаар засаглал эрсдэлгүй буюу 98.6%-аар үнэлэгдсэн. Ингэснээр хөрөнгийн биржид бүртгэлтэй 100 гаруй ААН-с компанийн засаглалын үйл ажиллагаагаар эхний 6 топ ААН-ийн эгнээнд орсон. Самбар харуулж байгаагаар эхний 2-т байна. Энэ нь олон улсын үнэлгээнд засаглал бол хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг юм. Хөрөнгө оруулагчдын зүгээс хамгийн эхэнд хардаг зүйл бол компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хардаг. Энэ үзүүлэлтүүдээ амжилттай сайжруулж чадсанаар томоохон амжилт гэж харж байна. Мөн хүний нөөцийн чиглэлээр тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр СЭЗИС-тай хамтран даатгалын салбарын хүний нөөцийг бэлтгэх, цаашлаад даатгалын салбарт бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчнүүд тогтвор суурьшилтай ажиллаж энэхүү салбарын өсөлт хөгжилтөд тодорхой хувь нэмрийг оруулна гэсэн ийм бодлогын хүрээнд ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Залгамж халааг урьдчилан тооцоолж бэлтгэж бодлогын түвшинд хэрэгжих томоохон ажлуудын нэг болсон. Даатгалын салбарт боловсон хүчний зах зээл нилээд хүндрэлтэй нөхцөл байдаг. Бусад салбарын хувьд ч хүний нөөцийн асуудал хүндрэлтэй нөхцөл байдал бий болсон. Иймд салбарын хувьд хүний нөөцийн асуудалд тодорхой хэмжээний түлхэц болж залгамж халаагаа бодлогын түвшинд бэлтгэх ажил болж өгсөн болов уу гэж харж байна.

Олон улсын харилцаа хамтын ажиллагааны хувьд оны эхээр Японы тэргүүлэгч даатгалын компанитай биечилсэн бизнес уулзалтыг хийсэн. Одоогийн байдлаар хараахан үр дүн гараагүй ч энэхүү уулзалтаар даатгалын салбарын олон улсын хөгжлийн чиг хандлага цаашдын чиг хандлагын талаар мэдээллүүдийг авч чадсан бизнес аялал болж чадсан гэж үзэж байна.

Баталгааны зах зээлд баталгааны бүтээгдэхүүнийг хийж эхэлсэнтэй холбоотой Лондонд төвтэй давхар даатгагч компанитай баталгааны даатгалын чиглэлээр хамтын ажиллагаа эхлүүлсэн. Энэ нь эхний хагас жилд зурагдаагүй ч гэсэн 7-р сард хамтын ажиллагааны чиглэлээр гарын үсэг зурсан. Энэхүү мэдээлэл маань удахгүй олон нийтийн зах зээлд мэдээлэл нь хүрнэ.

Үйл ажиллагааны хувьд эхний хагас жилийг энэхүү ололт амжилттайгаар өнгөрүүллээ. Дараагын санхүүгийн тайланг танилцуулая.

Бид эхний хагас жилд нийт хөрөнгийг 66, 5 тэрбум төгрөгт хүргэлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13%-ийн өсөлттэй. Нийт хураамж 30,2 тэрбумд хүрсэн. Өмнөх оныхтой харьцуулахад 4%-ийн өсөлттэй. 4%-ийн өсөлт нь харьцангуй эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөнд хүрээгүй ч төлөвлөж байсан томоохон гэрээнүүд 7-р сард хойшилж

зурагдсантай холбоотой төлөвлөгөөний гүйцэтгэл гарсан ч төлөвлөгөөнд хүрээгүй харагдаж байна. Гэхдээ 7,8-р саруудад төлөвлөгөө 90%-тай гарсан. Цэвэр ашгийн хувьд 4,8 тэрбумд хүрсэн. Энэ нь өмнөх мөн үетэй харьцуулахад 98,5 буюу 99%-ийн өсөлттэй гарсан. Энэ нь бидний хувьд чамлахааргүй эерэг үзүүлэлт. Ингэснээр өөрийн хөрөнгө өсөлттэй гарсан. Өөрийн хөрөнгийн хэмжээ 20,3 тэрбумд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48% өссөн байна. Өөрийн хөрөнгийн хувь хэмжээ 26,2%-тай өмнөх жилд 18,7% тай байсан байна. Актив өгөөж 8,6%, өмнөх жил 4,8%-тай байсан буюу өмнөх жилтэй харьцуулахад 3,8% иар өссөн үзүүлэлттэй гарсан байна. Эдгээр санхүүгийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүйгээр та бүхэндээ харуулья. Сүүлийн 3 жилийн дундажыг та бүхэндээ харуулж байна. 2024 оны эхний хагас жилд нийт хураамжийн орлого 16,7 байсан бол 2025 онд 19,1, 2026 онд 30,2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Орлого тооцсон хураамжийн хэмжээ 2024 онд 11, 2025 онд 13,9, 2026 оны 6 сард 13,4 буюу өмнөх жилтэй харьцуулахад өсөлтгүй 3,7% -ийн бууралттай харагдаж байна. Энэ нь 6 сард төлөвлөгдөж байсан зарим томоохон гэрээний сунгалт 7 сард хийгдсэнтэй холбоотой бууралттай харагдаж байгаа гэдгийг та бүхэнд хэлэх нь зүйтэй болов уу.

Нийт нөхөн төлбөрийн хэмжээ 2024 онд 6,2 тэрбум, 2025 оны 6 сард 4,8 тэрбум, 2026 онд 6 сард 5,9 тб болж өссөн байна. Энэ жилийн нөхөн төлбөрийн өсөлт харьцангуй өссөнг та бүхэн харж байна. Энэхүү өсөлтөд эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөрт томоохон хохирол нилээд гарсан. Нөгөө талаар 2023 онд зарим нэг томоохон үер усны нөхөн төлбөрийн кейсүүд үүссэн. Энэ нь 3 жил дараалан шүүхээр явж байгаад шийдэгдсэн. Эдгээр хүчин зүйлүүд нөхөн төлбөрийн өсөлтөд тодорхой хэмжээнд нөлөөлснийг та бүхэндээ дуулгах нь зөв юм.

Даатгалын үйл ажиллагаан ашгийг та бүхэнд харуулж байна. 2024 оны 6 сард даатгалын үйл ажиллагаа ашиг 0,7, 2025 онд 4тб, энэ жилийн хувьд 10,9 тб буюу өмнөх онтой харьцуулахад 172,5%-иар өссөн байна. Үүнийг бид чанарын үзүүлэлт гэж харж байна. Хэдийгээр хураамжийн орлого төдлийлөн төлөвлөснөөс өсөлт багатай боловч даатгалын үйл ажиллагааны ашиг болон нийт компанийн ашигт ажиллагаа тогтмол сайн өсөлтийг үзүүлж байгаа нь бидний чанарын үзүүлэлтийг батлан харуулж байна.

Орлогын дэлгэрэнгүйг харуулж байна. Даатгалын хураамжын цэвэр орлого хамгийн дээр харагдаж байна. Орлого тооцох хураамж 2024 онтой харьцуулахад өсөлттэй, өмнөх оны мөн үетэй харьцуулахад төдийлөн өсөлтгүй гарсан. Бидний цаашид хамгийн гол анхаарах зүйл бол борлуулалтын орлогын өсөлт гэдгийг энэ үзүүлэлт харуулж байна.

Нөхөн төлбөрийн цэвэр зардал харьцангуй тогтмол 2024 онд 4,6 тб, 2025 онд 3,3 тб болж буурсан. 2026 онд 4 тб болж өссөн. Өмнө нь дурьдсан хүчин зүйлийн нөлөөлөл байгааг та бүхэн анзаарсан байх. Үйл ажиллагааны зардлыг хувьд тогтмол 10 орчим хувийн өсөлттэй байгаа. 2024 оны 6 сард 4,2 тб, 2025 оны 6 сард 4,9 тб байсан бол 2026 оны тайлант үед 5,4 тб болж 10,9%-иар өссөн.

Давхар даатгалын үйл ажиллагааны шимтгэлийн орлого өмнөх жилтэй харьцуулахад 12,1%-ийн өсөлттэй гарсан байна. Сүүлийн 3 жилийн хугацаанд харьцуулаад үзэхэд харьцангуй 8-10 орчим хувийн өсөлттэй явж байна. Энэ жилийн төлөвлөгөөнд бид өмнөх жилтэй харьцуулахад нилээн өсөлттэй, амбицтай төлөвлөгөөг баталсан. Үүний гол өсөлт хийх зах зээлийн бүтээгдэхүүн нь тээврийн хэрэгсэл, хөрөнгө, хариуцлага гэсэн бүтээгдэхүүнийг төлөвлөсөн. Мөн давхар даатгалын хураамжийг өсөлт хийхээр төлөвлөсөн.

Хөрөнгө оруулалтын орлого эерэг үзүүлэлттэй гарсан. 2024 оны 6 сард 1,3 тб, 2025 оны 6 сард 1,7 тб, 2026 онд 2,1 тб-ийн өгөөжтэй буюу өмнөх жилтэй харьцуулахад өсөлттэй гарсан. Энэхүү өсөлт нь компанийн үйл ажиллагааны ашгийн өсөлтөд голлох нөлөөллийг бий болгож байна. Ашгийн өсөлтөд гол нөлөөлж буй 2 хүчин зүйл байна. Хөрөнгө оруулалтын өгөөж болон нөхөн төлбөрийн үйл ажиллагааны менежмент нөлөөлж байна.

Зардал болон ашигт ажиллагааны харьцааг харж байна. Бид 2026 онд зах зээлдээ томоохон өсөлтийг хийхээр зорьж байгаа ба харьцаа үзүүлэлтүүд дээр бууралт хийнэ. Гол харьцаа үзүүлэлтүүдийг байж болох эрүүл түвшинд авааачих зорилготой байна. Үүний нэг нь зардлын харьцаа, хохирлын харьцаа, хосолсон харьцаа гэх мэтчилэн үзүүлэлтүүдийг зорьсон. Үүнээс дурьдвал хохирлын харьцаа 43,9%тай, зардлын харьцаа 58,6% дээр ирснээр хосолсон харьцаа 102,5% болж буурсан. Энэхүү үзүүлэлтийг 2024 оны 6-р сард 112%тай, өнгөрсөн онд 87,5%-тай, жилийн эцсээр 116% тай гарсан. Энэ харьцааг 100-с дотогшоо болгох зорилтыг тавьж ажиллаж байгаагын хувьд хагас жилийн байдлаар 112,5 хувьтай гарсан байна. Оны эцэст энэ үзүүлэлтийг тогтмол аль болох барьж энэ түвшинд жилээ өндөрлүүлж ажиллахаар төлөвлөж байна. Давхар даатгалын хураамжийн зардал 10,6%-иар нэмэгдсэнтэй холбоотойгоор цэвэр хураамжийн орлого тодорхой хэмжээнд буурсан. Нөөц сангийн хэмжээ 36,3 тб-д хүрсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5,6%-иар буюу 2 тб төгрөг орчим өссөн. Цэвэр ашиг 4,8 тб гарсан.

Нөхөн төлбөрийн үзүүлэлт харагдаж байна. 2026 оны эхний хагас жилд компани нийт 5,9 тб төгрөгийн нөхөн төлбөрийн зардал гаргаж ажиллаа. Үүнээс 28,8% буюу 1,7 тб төгрөгийг давхар даатгагчийн хариуцах хэсгийг хассанаар цэвэр нөхөн төлбөрийн зардал 4,2 тб төгрөгтэй гарсан. Үүнээс 170,3 сая төгрөгийг буруутай этгээдээс буцаан нэхэмжилэхээр бүртгэлд тусгасан. Бүтээгдэхүний төрлөөр нөхөн төлбөрийн дийлэнх хэсгийг гэнэтийн осол, эмчилгээний буюу эрүүл мэндийн нөхөн төлбөр. Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой жолоочийн хариуцлагын даатгал, албан журмын даатгал дээр голлох нөхөн төлбөрийн үзүүлэлтийг бүрдүүлж байна. Хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн нөөцийн сангийн томоохон өөрчлөлтийн дийлэнх хэсгийг давхар даатгагчид шилжүүлсэн нь давхар даатгалын гэрээ том хэмжээний хохирлоос компанийг үр дүнтэй хамгаалж байгаа энэ бодлогыг хэрэгжүүлж байгаа.

Санхүүгийн байдлын зарим үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй та бүхэнд харуулж байна. Бидний мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт дэлгэрэнгүй харагдаж байна. 2024 онд 21,2, 2025 оны 6 сард 25,9 тб, 2026 оны сард 8,7 тб-д хүрсэн байна. Энэ нь мөн үетэй харьцуулахад 11%-иар өссөн. Даатгалын авлага 2024 оны 6 сард 4,2 тб, 2025 оны 6 сард 10 тб, 2026 оны 6 сард 9,4 тб болсон. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6,7%иар буурсан. 2024 оны 6 сартай харьцуулахад өссөн шалтгаан нь 2025, 2026 МИАТ-ийн даатгалыг авч хамтран ажиллаж байна. Энэ 5-6 тб төгрөгөөр цэвэр авлагыг нэмэгдүүлж байна. 2025,2026 оны үеийн харьцуулахад даатгалын авлага 7,6 тб болж 6%-иар буурсан байгаа нь даатгалын авлагыг цэвэршүүлэх, бууруулах, даатгалын авлага дээр бодлогын хувьд үр дүнтэй хэрэгжиж байна. Бусад хөрөнгийн хувьд 10,2 тб-аас 23 тб-аас 28 тб. Мөн энэ онд 28,3тб болсон. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23,3%-иар өссөн. Эдгээрт МИАТ-н давхар даатгал бусад ААН-ийн давхар даатгал өсөлт өндөртэй харагдуулж байна. Нийт хөрөнгө нь 2024 онтой харьцуулахад 1,8 дахин өссөн. Мөн үетэй харьцуулахад 12,6%-иар өөрчлөгдсөн. Өмнөх оны мөн үед 59,1 тб, энэ жил 66,5тб болж өссөн байна. Даатгалын өглөг мөн давхар даатгалын өглөгтэй холбоотой өсөлттэй харагдаж байна. Нөөц сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,6%-иар

өссөн. Өмнөх жил 34,3 тб байсан бол 34,2 тб болж өссөн. Энэ бидний үйл ажиллагаа эрсдэлгүй чанарын үзүүлэлтийг илэрхийлэх гол үзүүлэлт нь нөөц сангийн өөрчлөлт юм. Эздийн өмч өмнөх онтой харьцуулахад 48,1%-иар өссөн байна. Үүний гол өсөлт нь ашгийн үзүүлэлт дээр өссөн байна. 2024 6 сард 12,1тб, 2025 оны 6 сард 13,7тб, энэ жил 20,2тб болж өссөн байна. Нийт хөрөнгө нь 66,5 тб болж гарсан байна.

Хороно оруулалтын дүн нийт 28,4тб болж өмнөх үсэс 17,1%-иар өссөн. Үүний 7,9% нь банкинд байршуулсан хадгаламжаас бүрдүүлж байгаа. Үнэт цаасны үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад 76.2%-иар оссон. Андрейтингаас тодорхой хэмжээний ашиггүй ажллаж байгаа учраас хөрөнгө оруулалтыг өгөөжөөс тодорхой хэмжээний ашгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийг зорин ажиллаж байна. Энэхүү шалтгаан нь үнэт цаасны багц өмнох онтой харьцуулахад өсөлт үзүүлсэн байгаа нь харагдаж байна. Хөрөнгө оруулалтын орлого эхний хагас жилийн байдлаар 2,1тб буюу 24.6%-иар өссөн байна. Бид жилийн эцсээр хөрөнгө оруулалтыг 4,3 тб гэж төлөвлөсөн. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 100% тай хангагдаад явж байгаа.

Санхүүгийн төлөвлөгөөний гүйцэтгэлээр орлогын өсөлт нийт хураамжаар нийт хөрөнгийг 65.8 тб гэж төлөвлөснөөс гүйцэтгэл 66.5 тб буюу 101%-тай гүйцэтгэл гарсан. Нийт хураамжыг 30.9тб-аас 30.1%-ийн гүйцэтгэлтэй. Цэвэр хураамжийн төлөвлөгөө 10 орчим хувийн тасралттай 17.2тб гэж төлөвлөснөөс 13.6% гарсан байна. Иймд үлдсэн хугацаандаа цэвэр хураамжийн төлөвлөгөөнд анхаарч ажиллах шаардлага үүссэн. Нийт нөхөн төлбөр 7.4 тб-аас 5.8 тб -тай гүйцэтгэл 79.6% тай байгаа нь ашигт нөлөөлж буй гол хүчин зүйлс байна. Ерөнхий удирдлагын зардал буюу үйл ажиллагааны зардал нь 6,7 тб гэж төлөвлөснөөс 5.9 тб-ийн гүйцэтгэлтэй буюу 87%ийн гүйцэтгэлтэй. Мөн энэхүү зардлын менежментийн гол ашигт ажиллагаанд нөлөөлж байгаа нь гол хүчин зүйлсийн нэг юм. Ашигт ажиллагаа эхний хагас жилд 3.2 тб гэж төлөвлөснөөс 4.8 тб-тай гарч төлөвлөгөө 147.6%-ийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Санхүүгийн үзүүлэлтүүдийг сонирхолтой графикаар харуулж байна.

Төлбөрийн чадварын үзүүлэлт харагдаж байна. Эрсдэлгүй буюу 2-р түвшинд явж байна. Өнгөрсөн оны жилийн эцсээр мөн энэ түвшинд ажилласан. Энэ жилийн зорьж буй төлбөрийн чадварын түвшин бол 1-рүү орохыг зорьж байна. Санхүүгийн гол харьцаа тоон үзүүлэлтүүд дээр нилээн хүчин чармайлт гаргаж ажиллана. Төлөвлөж буй үзүүлэлтрүүгээ хүрэх зорилгын дагуу активийн чанарын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Эдгээр ажлууд нь жилийн эцсээр үр дүнгээ өгнө гэж үзэж байна. Ингээд компанийн эхний хагас жилийн санхүүгийн үзүүлэлтийг танилцуулж дууслаа.

Хурлын хэлэлцэх асуудлын дарааллын дагуу дараагийн асуудал руу шилжье.

Бид энэ жил компанийн брэндбүүкийг шинэчлэхээр төлөвлөгөөндөө тусган холбогдох төлөвлөлтийн дагуу ажлуудыг хийж гүйцэтгэж ажиллаа. Компанийн брэндбүүкийг шинэчлэх ажлын хүрээнд нилээдгүй ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Брэндбүүкийг шинэчлэх нь амаргүй бөгөөд нэг талдаа эрсдэлтэй ч нөгөө талаараа давуу тал эерэг нөлөө үзүүлэх ажил. Энэ асуудлаар мэргэжлийн компаниудтай хамтран ажиллаж тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Манай компани Богд групп гэсэн нэрийн доор нэгдсэн бодлоготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа. Гэвч бид мэргэжлийн байгууллагын зөвлөмж зах зээл дээр явуулсан судалгааг үндэслэн хэд хэдэн саналыг боловсруулж өнгөрсөн 7,8 сард ТУЗ-н

хурлаар өөрсдийн боловсруулсан санал хэлэлцүүлгээ танилцуулаад шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Групп компанийн дор нэрийг авах эсвэл тэс хөндлөн Б хувилбарыг танилцуулж түүнтэй холбоотой багагүй хугацааны судалгаа шинжилгээ нэр сонгох, лого сонгох ажлууд дээр цаг хугацаа зарцуулсан. Гэвч ТУЗ-ийн хурлаар бид Богд групп компанийн нэрийн дор Богд нэрийг аваад логог мөн групп компанийн логотой ижио хувилбараар явуулахаар шийдвэрлэсэн. Нэр "Богд даатгал" ХК гэж өөрчлөгдөнө. Логоны хувьд групп компанийн логог авч явахаар шийдвэрлэсэн.

Энэхүү нэрийг авснаар бид бүтэн шилжилтийг хийнэ. Дотооддоо хэрхэн ашиглах, хаягуудаа яаж байршуулах, албан хэрэгцээнд хэрхэн хэрэглэх, мерчантууд дээр хэрхэн байршуулах гэх мэт баталсан хувилбаруудаа харуулж байна. Энэхүү шинэ нэр, логотой холбоотой та бүхний зүгээс асууж тодруулах зүйлийг танилцуулгын дараа асууж болно. Энэхүү өөрчлөлт нь эерэг болон сөрөг талтай. Цаг хугацаа зарцуулж байгаагын хувьд нилээн ач холбогдол өгч бодлогын түвшинд бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж буй ажлууд дээр анхаарлаа хандуулж ажиллаж байна. Холбогдох байгууллагын журмын хүрээнд оноосон нэр өөрчлөх асуудал, лого шинэчлэх ажлууд нь ялангуяа ХК-ийн хувьд хэд хэдэн шат дараалллын дагуу явагддаг. Өнгөрсөн 8 сард ТУЗ-ийн хурлаар хэлэлцээд эхний шийдвэрийг гаргуулсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж Хувьцаа эзэмшигч нарт танилцуулаад тогтоолыг гаргуулсанаа үндсэн компанийн дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулаад СЗХ-нд хүргүүлээд эцэслэн шийдвэрлэх энэ процесс явагдана.

Компанийн оноосон нэр өөрчлөх тухай асуудлыг танилцуулъя. Компанийн нэрийг "Богд даатгал" болгон өөрчилж, дүрмийг шинэчлэн батлана. Бодь даатгал ХК гэхийг "Богд даатгал" ХК болгон өөрчлөн мөн дүрмийн нийтлэг үндэслэл хэсэгт дараах өөрчлөлтийг оруулна. Дүрмийн 1.1 "БОДЬ ДААТГАЛ Хувьцаат компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид "компани" гэх/ мөн" гэхийг 1.1 БОГД ДААТГАЛ Хувьцаат компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид "компани" гэх/ мөн. гэж өөрчлөх

Дүрмийн 1.3 Компанийн оноосон албан ёсны нэрийг

-монголоор: "БОДЬ ДААТГАЛ" ХК компани
-англиар: BODI INSURANCE гэхийг цаашид
-монголоор: "БОГД ДААТГАЛ" ХК компани
-англиар: BOGD INSURANCE гэх энэ өөрчлөлтүүдийг оруулж байна.

Ингээд хурлаас гарах шийдвэрийн дагуу асуулт хариултыг хүлээн авъя.

С.Дөлгөөн: Хурлыг зохион байгуулж буй комиссын зүгээс хувьцаа эзэмшигчиддээ мэдээлэл хүргэе. Хурлыг дамжуулж байгаа цахим систем нь дамжуулж буй дүрсний хажууд асуулт хариулт илгээх хэсэг идэвхижсэн нээлттэй байгаа. ХЭ та бүхэн хурлаас гарч буй шийдвэр ямар нэгэн асуулт санал хүсэлт байвал бичээд ирүүлнэ үү.

А.Энхжаргал: Хурлын дагуу асуулт, хариулт дэгийн дагуу 3мин үргэлжлэхийг санууллъя. Тооллогын комиссоос асуулт ирвэл танилцуулаарай.

-Асуулт1 ирсэн байна. Компани яагаад нэрээ сольж байгаа вэ? Давуу тал юу вэ?

А.Энхжаргал: Нэрийг сольж байгаа хэд хэдэн үндэслэл байна. 1т Бодь даатгал ХК нь зах зээлд үйл ажиллагаа явуулаад 31 дэхь жилдээ явж байна. Өнгөрсөн жил 30 жилийн ойн арга

хэмжээ болж харилцагч, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нартайгаа өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлсэн. Өнгөрсөн 31 жилийн хугацаанд алдаа гэхээс илүү оносон жилүүд болж өнгөрсөн. Иймдээ ч зах зээлийн тэргүүлэгчийн байр сууриа хадгалсаар ирсэн нь бидний амжилтыг харуулж байна. Хийж бүтээх үе ирж байна гэж үзэж байна. Дараагийн 30 жилд бизнесээ дараагийн түвшинд аваачиж томруулах зах зээл дээрх байр сууриа илүү бататгах цаг хугацаа эхэлж байна гэж харж байна. Шинэ өнгө төрхөөр ажиллах нөхцөл үүссэн тул сүүлийн 2 жилээс судалгаа, шинжилгээг хийсэн. Үүний үр дүнд дараагийн зах зээл шинэ өнгө торохоор гарах нь зүйтэй гэж үзсэн. Та бүхний мэдэж байгаачлан 1989 оноос Бодь групп-ийг үүсгэн байгуулсан. Бодь даатгалыг 1995 онд үүсгэн байгуулсан. Бодь нэр нилээн брэнд болж байсан түүхтэй. 2013 оноос компанийн хувьцаа эзэмшигчид салснаас хойш Бодь даатгал компани нь Бодь интернешнлээс албан ёсоор тусдаа үйл ажиллагаа явуулаад Богд группийг үүсгэн байгуулсан. Одоогийн байдлаар Богд группийн дор Бодь даатгал, Бодь системс, Богд банк, Богд тауэр гэх компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Иймд Бодь даатгал нь Богд даатгал болон өөрчлөгдөж байна. Нөгөөтэйгүүр Бодь интернешнл, Бодь групп, Голомт зэрэг зах зээл дээр нэртэй холбоотой төөрөгдөл маш их байдаг. Энэ нь үйл ажиллагаанд эерэг болон сөрөгөөр ирдэг. Иймд нэрээ өөрчлөх шаардлага үүссэн тул 31 дэх жилдээ өөрсдийн хөгжлийн дараагийн 30 жилд өөрсдийн шинэ брэндбүүктэйгээр орох шийдвэр гаргаад өнөөдрийн процесс явж байна.

С.Дөлгөөн: ХЭ нар хурлын дэгийн дагуу нэмэлтээр асуух зүйл байвал асуугаад явъя.

А.Энхжаргал: Хурлын дэгийн дагуу дараах асуудал руу шилжье. Нэр болон дүрэмд өөрчлөлт оруулах асуудлаар санал өгөх процесс эхлэнэ. Үүний өмнө саналын хуудас бөглөх зааврыг тооллогын комисс танилцуулж өгнө үү.

С.Дөлгөөн: За баярлалаа, ХЭ та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Цахим системээр санал өгөх зааврыг товчхон танилцуулъя. Өнөөдрийн ээлжит бус хурлаар 4 асуудал хэлэлцэж байгаагын 2 нь танилцуулах 2 нь хэлэлцэж батлах асуудал байгаа. Та бүхний үзэж байгаа шууд дамжуулалтын дээд талд санал өгөх хэсэг байгаа. Зөвшөөрсөн, татгалзсан гэх саналаа өгөөд үргэлжлүүлэх товчыг дармагц өгч байгаа саналыг баталгаажуулах хэсэг гарч ирнэ. Сонголтоо хийгээд үргэлжлүүлэх товчыг дарснаар та бүхний санал эцсийн байдлаар баталгаажна. Энгийн аргаар санал өгөх 2 асуудал хэлэлцүүлж байгаа. Анхаарах зүйл нь 2 асуудлын талаар санал өгөхдөө хоёуланд саналаа огсний дараа идэвхитэй болно. Ингээд санал авах хугацаа тоологдож эхэллээ.

А.Энхжаргал: Санал авах нийт хугацаа 10 миниут үргэлжилнэ. Та бүхэн энэ хугацаанд багтаан саналаа өгнө үү.

С.Дөлгөөн: Хурлын дэгийн дагуу санал хураалтийн цаг дууссан байна. Саналыг албан ёсоор идэвхигүй болгож байна. Дэгийн дагуу тооллогын комисс саналын хуудсыг тоолж нэгтгэх хугацаа явж эхэллээ. Нэгтгэсний дараа тооллогын үр дүнг танилцуулъя баярлалаа.

Х.Сарангоо: Эрхэм хүндэт ХЭ-дээ тооллогын комисс дүнгээ нэгтгэж дууслаа. Гарсан шийдвэрийг танилцуулъя.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэр 2026 оны 9-р сарын 21-ний өдөр №2 Улаанбаатар хот

Бодь даатгал ХК-ийн ХЭ-дийн ээлжит бус хурлын хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. "Бодь Даатгал" ХК-ийн саналын эрхтэй нийт 231,931,348 ширхэг хувьцаанаас 77.64% буюу 180,078,247 ширхэг хувьцаа эзэмшиж буй 20 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

НЭГ Компанийн оноосон нэрийг өөрчилж хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 180,078,247 ширхэг хувьцаатай 20 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

ХОЁР. Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбоотой шинэчилсэн дүрмийн төслийг хэлэлцэн батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 180,078,247 ширхэг хувьцаатай 20 хувьцаа эзэмшигч хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

А.Энхжаргал: Тооллогын комисдоо баярлалаа, тооллогын комиссоос гарсан шийдвэрийн дагуу хурлаас гарах тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Тогтоол 1.

Бодь даатгал ХК ХЭ-ийн ээлжит бус хурлын тогтоол 2026 оны 09-р сарын 21, №26/06 Улаанбаатар хот.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 62.1.16 дахь заалтууд болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Бодь даатгал" ХК-ийн оноосон нэрийг "Богд даатгал" ХК (цаашид "Компани" гэх) болгон өөрчилсүгэй.
2. Оноосон нэр өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн хэрэгжиж буй бүхий л баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулахыг Гүйцэтгэх захирал /А.Энхжаргал/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА А.ЭНХЖАРГАЛ

Тогтоол 2.

Бодь даатгал ХК ХЭ-ийн ээлжит бус хурлын тогтоол 2026 оны 09-р сарын 21, №26/07 Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 62.1.16 дахь заалтууд болон Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2026 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бодь даатгал ХК (цаашид "Компани" гэх)-ийн оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор компанийн дүрмийг шинэчлэн, Хавсралт 1-ээр батлуулсугай.
2. Шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэст болон Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, өөрчлөлтэй холбоотой хийгдэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /А.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА А.ЭНХЖАРГАЛ.

Хурлын дэгийн дагуу асуудлаа хэлэлцэж батлаж дууслаа. Хуралдаа оролцсон нийт ХЭ-дээ баярлалаа, мөн хурлыг цахимаар зохион байгуулж өгсөн Би ди сек болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ажлын хэсэгтээ, ТУЗ-ийн даргадаа баярлалаа. Хурлыг албан ёсоор хааж байна.

Ө.Батчимэг: Бодь даатгал ХК-ийн ХЭ ээлжит бус хурал 12:27 минутад өндөрлөж байна. Баярлалаа.

Хурлын дарга: А.Энхжаргал /.....

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Ө.Батчимэг /.....

“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 21-ний өдөр №1 Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 67, 69.1, 69.2 болон “Бодь Даатгал” ХК-ийн компанийн дүрмийн 7.4, “Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Бодь Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд **180,078,247** ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 20 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий **231,931,348** ширхэг хувьцааны **77.64%** болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1, 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 7.4 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны **77.64%**-ийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Тооллогын комиссын дарга: Х.Сарангоо

Тооллогын комиссын гишүүн: Ж.Наранцэцэг

Тооллогын комиссын гишүүн: О.Энхжин

Тооллогын комиссын гишүүн: С.Дөлгөөн